

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14 дүгээр зүйл.Албаны нууцад хамаарах мэдээлэл

14.1.Албаны нууцад дараах шаардлагыг хангасан мэдээллийг хамааруулна:

14.1.1.тухайн мэдээлэл нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүний эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн байх;

14.1.2.тухайн мэдээллийг ил тод, нээлттэй болгох, бусдад дамжуулах, өгөх нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд хохирол учрахыг тогтоосон байх;

14.1.3.энэ хуулийн 14.1.2-т заасан учрах хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлоос давахааргүй байх.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан үндэслэлээр албаны нууцад хамааруулсан хэдий ч тухайн мэдээлэл нь төрийн байгууллага, бусад хуулийн этгээд, албан тушаалтны хууль бус үйлдлийг нуух зорилготоор мэдээллийг албаны нууцад хамааруулахыг хориглоно.

14.3.Тухайн байгууллага албаны нууцад хамаарах мэдээллийг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Тагнуулын байгууллагын дарга батална.

14.4.Тухайн байгууллага нь албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд багтаан дүн шинжилгээг жил бүрийн эхний улиралд хийнэ.

14.4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хязгаарлалттай мэдээллийг өгөхөөс татгалзсан бол татгалзсан үндэслэлээ тухайн байгууллага тайлбарлах үүрэгтэй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон албаны нууцын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.8-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.” гэж, мөн 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дахь заалтын 1 дүгээр үе шат(2021-2030)-ны гэж тус тус заасан байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.4.1-д “Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана.” гэж заасан.

2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан, 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй байхаар заасан.

Гэвч төрийн байгууллага, албан тушаалтнууд хуульд ил тод, нээлттэй байхаар заагаагүй бөгөөд нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг “албаны нууц”-д хамааруулан тогтоох боломжтой байгаа албаны нууцын талаарх эрх зүйн зохицуулалт буюу Төрийн болон албаны нууцын тухай хууль дахь зохицуулалт нь иргэний Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл авах эрхийг хөндөхөд хүрч байна гэсэн шүүмж гарсаар байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хуульд ил тод, нээлттэй байхаар заагаагүй бөгөөд нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг албаны нууцад хамааруулахгүй байх, үүний тулд албаны нууцад хамааруулах мэдээллийн шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгалаа.

Албаны мэдээллийг тухайн байгууллагын дарга баталж байгааг өөрчилж, тагнуулын байгууллагын дарга баталдаг байхаар тусгав.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ